

ТӨСӨЛ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 252 дугаар зүйлийн 252.8, 256 дугаар зүйлийн 256.7, 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.11, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны ... дугаар сарын ...-ний өдрийн хуралдааны .../... тоот шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

НЭГ: Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны “Журам батлах тухай” А/315 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ын 2.3, 2.5, 2.7, 2.8, 2.14, 3.16, 4.5, 4.6, 5.1, 5.2, 5.3, 5.6, 5.12, 5.21, 5.22, 5.23, 5.24 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2.3. Гаалийн улсын байцаагч нь бараанд МШХШ гаргасан талаар мэдүүлэгчид нэн даруй танилцуулна.

2.5. Гаалийн улсын байцаагч мэдүүлэгчийг байлцуулан Монгол Улсын холбогдох стандартын дагуу барааны шинж, төрөлөөс хамаарч бараанаас сорьц, дээж, загварыг авч /шаардлагатай бол барааны фото зургийг хавсарган/, битүүмжлэн, CAIS програмд МШХШ-ийг 2 хүртэл хоногийн дотор бичнэ.

2.7. Гаалийн улсын байцаагч нь лабораторийн дүгнэлтийн CAIS програмын “Маягт бичих” талбарт мэдүүлсэн бараатай холбоотой мэдээллийг худалдааны бичиг баримттай уялдуулан “Цахим төлбөрийн баримтын систем”-д бүртгэгдсэн гэрээний дугаарыг МШХШ-т оруулан, энэ журмын 2.5-д заасан хугацаанд хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид хянуулахаар илгээнэ.

2.8. Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч магадлан шинжилгээнд хамрагдах бараа, тээврийн хэрэгслийн мэдээллийг 1 хүртэл хоногийн дотор хянаж баталгаажуулснаар сорьц, дээж, загварын бүртгэлийн дугаар CAIS програмд автоматаар үүсэж, гаалийн лабораторид цахимаар илгээгдсэн үеэс лабораторийн дүгнэлт гарах хүртэлх хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа түр зогсоно.

2.14. Энэхүү журмын 2.13-д заасан тохиолдолд сорьц, дээж, загвар авсан гаалийн улсын байцаагч “Лабораторийн шинжилгээний хураамж”-ийг МШХШ-ийн бүртгэлийн дугаараар CAIS програмд энэ журмын 2.5, 2.7, 2.8-д заасан хугацаанд нэхэмжлэх үүсгэсэний дараа мэдүүлэгч төлбөрийг төлүүлж, гаалийн лабораторид МШХШ-ийг илгээнэ.

3.16. Барааны нэр төрөл, онцлогоос хамаарч тэдгээрийг хадгалах хугацаа, нөхцөл харилцан адилгүй өөр өөр байдаг бөгөөд түргэн гэмтэж муудах барааны сорьц, дээж, загвар нь иргэн, хуулийн этгээд үлдэгдэл дээжийг энэ журмын 9 дүгээр

хавсралтад заасан хугацаанд буцаан аваагүй тохиолдолд энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэл хөтлөн албан ёсоор мэдэгдэж, устгалд оруулна.

4.5.Гаалийн лаборатори нь дараах үндэслэлээр магадлан шинжилгээ хийхээс татгалзана:

4.5.1.Бараанаас сорьц, дээж, загвар авах аргачлалын дагуу сорьц, дээж, загварыг олон улсын болон Монгол Улсын холбогдох стандартад заагдсан тоо хэмжээгээр ирүүлээгүй;

4.5.2.Магадлан шинжилгээнд ирүүлсэн сорьц, дээж, загвар нь баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан, битүүмжлэлгүй, асгарсан, хадгалах хугацаа дууссан;

4.5.3.Энэ журмын 4.4-т заасан бичиг баримт бүрдэл болоогүй;

4.5.4.Бараанд магадлан шинжилгээ хийхгүйгээр “Барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем”-ийн холбогдох тайлбарыг үндэслэн барааны ангиллын кодыг тодорхойлох боломжтой;

4.5.5.Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод тусгагдаагүй бараа, бүтээгдэхүүний сорьц, дээж, загвар ирүүлсэн.

4.6.Энэ журмын 4.5-д заасан үндэслэлээр магадлан шинжилгээ хийхээс татгалзсан тухай шийдвэрийг мэдүүлэгчид 1 хүртэл хоногийн дотор ирүүлсэн сорьц, дээж, загвар, дагалдах бичиг баримтын хамт албан бичгээр гарган мэдүүлэгч эсхүл тухайн гаалийн байгууллагад буцаана.

5.1.Харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн битүүмжлэгдсэн сорьц, дээж, загварыг дээж хүлээн авах ажилтан МШХШ болон дагалдах бичиг баримттай тулган шалгаж, “Лабораторийн шинжилгээний хураамж”-ийн нэхэмжлэлийг үүсгэж, дээжийг хүлээн авч, тухайн лабораторийн ачааллаас хамаарч 2 цагийн дотор бүртгэнэ.

5.2.Сорьц, дээж, загвар хүлээн авах ажилтан нь эрдэс, түүхий эд, хүдэр, баяжмал болон нүүрсний сорьц, дээж, загварыг МШХШ-ийн бүртгэлийн дугаар болон битүүмжлэлийн дугаараар лаборантад нэн даруй хүлээлгэн өгнө.

5.3.Лаборант нь лабораторийн менежментийн мэдээллийн системийн програм /цаашид “LIMS” програм гэх/-д бүртгэж, сорьц, дээж, загварыг холбогдох стандартын дагуу, стандартад заагдсан хугацаанд буталж, нунтаглан, дубликат дээжийг хуваан авч хадгалах ба шинжилгээнд зориулан бэлтгэсэн аналитик дээжийг магадлан шинжилгээ хийх—шинжээч ГУБ-д хүлээлгэн өгч, холбогдох бүртгэлийг хөтөлнө.

5.6.Шинжээч ГУБ өөрт хуваарилагдсан сорьц, дээж, загварт олон улсын болон Монгол Улсын стандарт арга, аргачлалын дагуу стандартад заагдсан хугацаанд магадлан шинжилгээг хийж, LIMS програмд мэдээллийг оруулж, сорилтын үр дүнг чанарын менежер ГУАБ-аар хянуулахаар илгээнэ. Чанарын менежер ГУАБ нь

шинжилгээний үр дүнг холбогдох стандартын үзүүлэлттэй харьцуулан, хүлээн зөвшөөрсөн тохиолдолд ахлах шинжээч ГУАБ болон гаалийн лабораторийн даргад баталгаажуулахаар илгээснээр “Илгээсэн төлөв”-т шилжинэ. Гаалийн салбар лабораториудад чанарын менежерийн үүргийг шинжээч ГУАБ гүйцэтгэнэ.

5.12. Дүгнэлт гаргах шинжээч ГУБ нь “Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн”-г үндэслэн “Барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем”-ийн холбогдох тайлбар болон ерөнхий тайлбар дүрмийн дагуу барааны ангиллын кодыг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд бараанд нэмэлт судалгаа хийж, дүгнэлтийг CAIS програмд бичиж, хянуулахаар ахлах шинжээч ГУАБ-д, илгээснээр “Дүгнэлт хянуулах төлөв”-т шилжинэ.

5.21. Харьяа гаалийн газар, хороодын бичиг баримтын бүрдүүлэлт болон хяналт шалгалт хариуцсан ГУБ магадлан шинжилгээний дүгнэлтээр зөрчил илэрсэн барааг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг CAIS програмын холбогдох талбарт оруулж, гаалийн лабораторид нэн даруй илгээнэ.

5.22. Магадлан шинжилгээний дүгнэлтээр мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис илэрсэн тохиолдолд уг мэдээллийг гаалийн удирдах төв байгууллагын зөрчлийн асуудал хариуцсан нэгж болон тухайн гаалийн газар, хороонд албан ёсоор мэдэгдэж шаардлагатай бусад арга хэмжээг нэн даруй авч ажиллана.

5.23. Магадлан шинжилгээний дүгнэлтийн “Тайлбар” хэсэгт бичиг баримтын бүрдүүлэлт болон хяналт шалгалт хариуцсан ГУБ нарт шаардлагатай мэдээлэл, анхааруулгыг бичиж гаалийн хяналт, бүрдүүлэлт хийхдээ хэрэгжүүлнэ.

5.24. Магадлан шинжилгээ нь бусад итгэмжлэгдсэн лабораторид хийгдэх тохиолдолд магадлан шинжилгээний дүгнэлт гаргах шинжээч ГУБ-ийг лабораторийн дарга /шинжээч ГУАБ, эсхүл чанарын менежер ГУАБ/ програмаар томилно. Шинжээч ГУБ итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн магадлан шинжилгээний дүгнэлт гаргахдаа энэ журмын 5.12-5.15-д заасныг дагаж мөрдөнө.

ХОЁР. Энэхүү журамд дор дурдсан агуулга бүхий заалтыг нэмсүгэй:

2.17. Барааны нэр төрөл, сорьц, дээж, загвар авах аргачлал, байгалийн гамшиг, гэнэтийн болон *давагдашгүй хүчин* зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ журмын 2.5, 2.7, 2.8-д заасан хугацааг сунгаж болно.

4.8. Барааны нэр төрөл, шинжлэх үзүүлэлт, дээжний тоо зэрэг болон гэнэтийн, *давагдашгүй хүчин* зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд магадлан шинжилгээ хийх хугацааг сунгаж болно.

5.33. Барааны нэр төрөл, шинжлэх үзүүлэлт, дээжний тоо зэрэг болон гэнэтийн, *давагдашгүй хүчин* зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд магадлан шинжилгээ хийх хугацааг сунгаж болно.

Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны дугаар
тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж,
загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт
гаргах журам”-ын Есдүгээр хавсралт

Дээжийг хадгалах хугацаа, нөхцөл

№	Бүтээгдэхүүний нэр		Хадгалах хугацаа	Хадгалах температур
1	Мах, махан бүтээгдэхүүн	Түүхий бүтээгдэхүүн	12-24 цаг	(00)-(+40) С
		Боловсруулсан бүтээгдэхүүн	24-48 цаг	(00)-(+40) С
2	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Түргэн гэмтэх /тараг, сүү, иогурт, масло/	12-36 цаг	(+20)-(+40) С
		Боловсруулсан бүтээгдэхүүн	24-72 цаг	(+20)-(+60) С
3	Гурил, гурилан бүтээгдэхүүн	Түргэх гэмтэх	12-36 цаг	(+20)-(+60) С
		Боловсруулсан бүтээгдэхүүн /гоймон, бэлэн хоол/	24-72 цаг	(+20)-(+60) С
4	Далайн гаралтай бүтээгдэхүүн /загас, түрс, хавч, сам хорхой г.м/		24-48 цаг	(-20)-(+40) С
5	Жимс жимсгэнэ		24-48 цаг	(-20)-(+60) С
6	Хүнсний ногоо		24-48 цаг	(-20)-(+60) С
7	Архи спирт		3 сар	+180 С >
8	Виски, ликёр, дарс, вино		3 сар	+180 С >
9	Пиво /задгай пиво квас/		48-72 цаг	(+20)-(+60) С
10	Өндөг, өндгөн бүтээгдэхүүн		24-48 цаг	(+20)-(+60) С
11	Бүх төрлийн консервлосон бүтээгдэхүүн		7 хоног	+180 С >
12	Давс, элсэн чихэр		1 сар	(+80)-(+100) С
13	Чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн /хатуу зөөлөн чихэр, зөгийн бал/		1 сар	+180 С >
14	Шоколад, шоколадтай, кремтэй бүтээгдэхүүн		24-48 цаг	(+20)-(+40) С
15	Будаа /цагаан, шар/		1 сар	(+80)-(+100) С
16	Цай кофе, какао		1 сар	200 С-аас дээшгүй
17	Савласан ус, ундаа, эссенц		24-48 цаг	(+20)-(+60) С
18	Хоол амтлагчууд		7 хоног	+180 С >
19	Ургамлын тос масло, майонез		24-72 цаг	(+20)-(+60) С
20	Самар, мөөг /давсалсан, лаазалсан/		24-72 цаг	(+20)-(+60) С
21	Ваакумдаж савласан бүтээгдэхүүн /чипс, popcorn г.м/		7 хоног	+180 С >
22	Хүүхдийн хоол тэжээл		1-7 хоног	(+20)-(+60) С
23	Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн		1 сар	(00)-(+40) С
24	Тамхи		1 сар	+180 С >
25	Ундны ус		24 цаг	(-20)-(+40) С
26	Хөрс		24 цаг	(-20)-(+40) С
27	Эд материал, хуучин хувцас		24-72 цаг	+180 С >
28	Химийн бодис		1-2 сар	(-80)-(+80) С
29	Барилгын материал /будаг,цавуу, эмульс/		1-3 сар	+180С >
30	Хоолны хордлогын материалууд		24 цаг	(00)-(+40) С
31	Бүх төрлийн таримлын үр, үр тариа, ногооны үр		8-10 сар	(+180)-(+200) С
32	Эм, эмийн бүтээгдэхүүн		1-3 сар	(+180)-(+200) С
33	Тарилгын шингэн тун шилтэй эм		30 хоног	(00)-(+40) С

34	Шахмал болон капсултай эм	6 сар	(+180)-(+200) С
35	Ороох боох материал, хөвөн, бинт, мэс заслын утас, тариур, дуслын систем	1-6 сар	(+180)-(+200) С
36	Галени бэлдмэл	1 сар хүртэл	(00)-(+40) С
37	Тосон түрхлэг	3 сар	(00)-(+40) С
38	Эмийн түүхий эд	6-12 сар	(+180)-(+200) С

Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны дугаар тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ын Аравдугаар хавсралт

Дээж устгалын үйл ажиллагааны бүртгэл

1. Дээжний бүртгэлийн дугаар			
2. Дээжний нэр.....			
3. ААН-ийн нэр.....			
4. Дээж ирүүлсэн огноо.....			
5. Дээж хадгалах хугацаа.....			
6. Дүгнэлтийн дугаар.....			
7. Мэдүүлэгч/ААН-ийн холбогдох хүний албан тушаал	8. Мэдүүлэгч/ААН-ийн холбогдох хүний нэр	9. Дээж устгах тухай мэдээлэл өгсөн суваг	10. Дээж устгах тухай мэдээлэл өгсөн он сар
11. Дээж устгал хийж гүйцэтгэсэн шинжээчийн гарын үсэг, /нэр/:			
12. Тайлбар:			

ДАРГА

Р. ОТГОНЖАРГАЛ